



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/241

Мандалговь

Эрх шилжүүлэн ажил
гүйцэтгүүлэх тухай


Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: 2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр баталсан "Адаацаг сумын нийтийн ахуйн үйлчилгээний барилгын засвар"-ын ажлын эрхийг Адаацаг сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

Хоёр: Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг гүйцэтгэгчтэй хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэн, үе шатны ажилд тавих хяналтыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг Адаацаг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг)-д үүрэг болгосугай.

Гурав: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.3 дахь заалтыг үндэслэн эрх шилжүүлэн гүйцэтгүүлж байгаа хөрөнгө оруулалт, ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200701